

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/155/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2025 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
Аймгийн ИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

2025.02.25 № 259
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 2,833.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 2,478.7 сая төгрөг зарцуулж, 87.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.АЙГҮЛ



Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>278,780,449.20</u>	<u>410,970,502.03</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	142,436,958.00	236,142,494.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	142,436,958.00	236,142,494.24
3121	Төгрөг	142,436,958.00	236,142,494.24
31211	Төрийн сангийн харилцах	142,436,958.00	236,142,494.24
33	АВЛАГА	9,904,518.20	7,163,813.79
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9,904,518.20	7,163,813.79
35	БАРАА МАТЕРИАЛ	126,438,973.00	167,664,194.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	360,000.00
354	Хангамжийн материал	126,438,973.00	167,304,194.00
35420	Аж ахуйн материал	95,135,147.00	95,135,147.00
35440	Түлш, шатах тослох материал	49,000.00	-
35450	Барилгын засварын материал	115,000.00	-
35460	Хүнсний материал	13,939,426.00	7,703,492.00
35470	Бусад хангамжийн материал	17,200,400.00	64,465,555.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,411,413,698.97</u>	<u>1,534,757,834.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,411,413,698.97	1,534,757,834.97
392	Биет хөрөнгө	1,369,990,459.97	1,493,809,009.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,458,854,320.55	1,556,654,319.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	(300,392,794.32)	(365,909,755.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	238,157,491.40	348,838,231.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(107,853,265.44)	(142,455,717.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	139,858,914.71	171,558,930.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	(91,680,561.77)	(108,649,683.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,800,000.00	13,600,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,360,000.16)	(11,080,000.00)
39217	Ном	29,606,355.00	31,252,683.84
393	Биет бус хөрөнгө	41,423,239.00	40,948,825.96
39301	Програм хангамж	1,973,239.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(1,024,413.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,690,194,148.17</u>	<u>1,945,728,337.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,690,194,148.17</u>	<u>1,945,728,337.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,690,194,148.17	1,945,728,337.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	476,976,577.00	476,976,577.00
51101	Өмч: - төрийн	476,976,577.00	476,976,577.00

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

512	Хуримтлагдсан үр дүн	209,784,234.12	465,318,422.95
51210	Өмнөх үеийн үр дүн	93,395,766.43	209,784,234.12
51220	Тайлант үеийн үр дүн	116,388,467.69	255,534,188.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,003,433,337.05	1,003,433,337.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,690,194,148.17	1,945,728,337.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,012,916,299.00	2,828,004,661.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,271,639.00	254,832,461.20
120	Нийтлэг татварын бус орлого	94,271,639.00	254,832,461.20
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	1,608,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,608,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	94,271,639.00	209,956,106.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	43,267,555.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,918,644,660.00	2,573,172,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,764,455,400.00	2,418,653,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,764,455,400.00	2,418,653,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	154,189,260.00	154,518,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	154,189,260.00	154,518,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,896,527,831.31	2,570,287,150.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,896,527,831.31	2,570,287,150.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,849,188,427.31	2,514,743,940.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,160,562,536.48	1,872,354,953.66
210101	Үндсэн цалин	1,157,870,546.48	1,828,827,596.25
210102	Нэмэгдэл	2,191,990.00	35,606,303.00
210104	Урамшуулал	500,000.00	7,921,054.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	307,269,193.00	242,551,300.00
210201	Тэтгэврийн даатгал	307,269,193.00	164,935,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	19,404,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	9,702,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	9,702,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	38,808,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	152,156,848.00	150,727,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,954,559.00	11,400,000.00

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	146,773,289.00	139,327,000.00
210303	Цэвэр, бохир ус	429,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	60,000.00	-
210401	Бичиг хэрэг	60,000.00	-
2105	Нормативт зардал	66,849,840.00	78,379,800.00
210502	Хоол, хүнс	66,804,840.00	78,379,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	45,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,425,300.00	806,500.00
210604	Урсгал засвар	1,425,300.00	806,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,264,000.00	7,801,729.51
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,264,000.00	7,801,729.51
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,600,709.83	162,122,656.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,195,590.00	29,214,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,337,529.00	12,625,259.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,067,590.83	120,282,947.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,339,404.00	55,543,210.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,339,363.00	53,202,710.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,618,000.00	46,887,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,721,363.00	6,315,210.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	41.00	2,340,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	41.00	2,340,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	116,388,467.69	257,717,511.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,183,322.36
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	2,183,322.36
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(2,183,322.36)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	116,388,467.69	255,534,188.83

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,928,515,400.00	2,574,781,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,608,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,608,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,608,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,608,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,928,515,400.00	2,573,172,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,764,455,400.00	2,418,653,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,764,455,400.00	2,418,653,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,060,000.00	154,518,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,060,000.00	154,518,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,797,170,102.00	2,445,221,163.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,797,170,102.00	2,445,221,163.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,742,214,161.00	2,382,357,953.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,295,451,454.00	1,869,314,049.25
210101	Үндсэн цалин	889,863,175.00	1,177,047,542.26
210102	Нэмэгдэл	322,177,064.00	609,520,434.99
210104	Урамшуулал	83,411,215.00	82,746,072.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,455,300.00	242,551,500.00
210201	Тэтгэврийн даатгал	115,229,400.00	164,935,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,556,300.00	19,404,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,845,300.00	9,702,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,711,300.00	9,702,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,113,000.00	38,808,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,718,080.00	150,678,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,650,059.00	11,400,000.00
210302	Түлш, халаалт	160,068,021.00	139,278,000.00
2105	Нормативт зардал	64,727,500.00	64,823,866.00
210502	Хоол, хүнс	64,727,500.00	64,823,866.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,414,000.00	7,801,729.51
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,414,000.00	7,801,729.51

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,347,827.00	45,688,809.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,201,227.00	32,763,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,146,600.00	12,925,259.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,955,941.00	62,863,210.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,955,900.00	60,522,710.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,265,500.00	54,207,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,690,400.00	6,315,210.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	41.00	2,340,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	41.00	2,340,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	131,345,298.00	129,559,836.24
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,376,200.00	35,854,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,376,200.00	35,854,300.00
2200	Догоод эх үүсвэрээр	37,376,200.00	35,854,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,376,200.00	35,854,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(37,376,200.00)	(35,854,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,369,098.00	93,705,536.24
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	48,467,860.00	142,436,958.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	142,436,958.00	236,142,494.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	93,395,766.43		1,573,805,680.48
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	93,395,766.43	0.00	1,573,805,680.48
C07	Тайлант үеийн үр дүн			116,388,467.69	0.00	116,388,467.69
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	209,784,234.12	0.00	1,690,194,148.17
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	209,784,234.12	0.00	1,690,194,148.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	209,784,234.12	0.00	1,690,194,148.17
D08	Тайлант үеийн үр дүн			255,534,188.83	0.00	255,534,188.83
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	465,318,422.95	0.00	1,945,728,337.00

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Багтагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		142,436,958.00		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,833,962,500.00	2,478,734,963.76	(355,227,536.24)	87.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,833,962,500.00	2,478,734,963.76	(355,227,536.24)	87.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,768,044,300.00	2,418,212,253.76	(349,832,046.24)	87.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,968,889,200.00	1,869,314,049.25	(99,575,150.75)	94.9
210101	Үндсэн цалин	1,338,486,900.00	1,177,047,542.26	(161,439,357.74)	87.9
210102	Нэмэгдэл	566,754,500.00	609,520,434.99	42,765,934.99	107.5
210104	Урамшуулал	66,648,800.00	82,746,072.00	19,098,272.00	130.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,111,100.00	242,551,500.00	(3,559,600.00)	98.6
210201	Тэтгэврийн даатгал	167,355,600.00	164,935,100.00	(2,420,500.00)	98.6
210202	Тэтгэмжийн даатгал	19,689,000.00	19,404,200.00	(284,800.00)	98.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,844,400.00	9,702,000.00	(142,400.00)	98.6
210204	Ажилгүйдлийн даатгал	9,844,400.00	9,702,000.00	(142,400.00)	98.6
210205	Эрүүл мэндийн даатгал	39,377,700.00	38,808,200.00	(569,500.00)	98.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	283,544,000.00	150,678,000.00	(132,866,000.00)	53.1
210301	Гэрэл, цахилгаан	11,400,000.00	11,400,000.00	-	100.0
210302	Түлш, халаалт	270,144,000.00	139,278,000.00	(130,866,000.00)	51.6
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	-	(2,000,000.00)	-
2105	Нормативт зардал	147,017,300.00	64,823,866.00	(82,193,434.00)	44.1
210502	Хоол, хүнс	147,017,300.00	64,823,866.00	(82,193,434.00)	44.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	31,709,200.00	19,341,729.51	(12,367,470.49)	61.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	1,608,800.00	-	(1,608,800.00)	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,100,400.00	19,341,729.51	(10,758,670.49)	64.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,273,500.00	70,003,109.00	(19,270,391.00)	78.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,036,700.00	57,077,850.00	(18,958,850.00)	75.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,236,800.00	12,925,259.00	(311,541.00)	97.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,918,200.00	60,522,710.00	(5,395,490.00)	91.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,918,200.00	60,522,710.00	(5,395,490.00)	91.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,901,300.00	54,207,500.00	(4,693,800.00)	92.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,016,900.00	6,315,210.00	(701,690.00)	90.0
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,833,962,500.00	2,572,440,500.00	(261,522,000.00)	90.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,418,653,700.00	2,418,653,700.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,418,653,700.00	2,418,653,700.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	285,044,000.00	152,178,000.00	(132,866,000.00)	53.4
132001	Орон нутгийн төсвөөс	285,044,000.00	152,178,000.00	(132,866,000.00)	53.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	130,264,800.00	1,608,800.00		1.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,608,800.00	1,608,800.00		100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	128,656,000.00			-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	142,436,958.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	236,142,494.24	236,142,494.24	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	81	77		4
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	50	52		(2)
620003	Үйлчлэх ажилтан	29	23		6
620004	Гэрээт ажилтан	1	1	-	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	481	458		23
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ	481	458		23
630001	Төрийн өмчит ЕБС	481	458		23
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	81	77		4
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	1	1	-	
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	48	46		2
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1	-	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	30	28		2
650010	Гэрээт ажилтан	1	1	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

БӨА-2025/155/НА-СТА-ТШЗ

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Багш бүр тасралтгүй хөгжин, асран хамгаалагч нартай хамтран ажиллаж, хос хэлний сургалтын аргыг нэвтрүүлэн, сургуулийн менежментийг хөгжүүлж, хүүхдүүдийн хүмүүжил төлөвшил, мэдлэг чадварыг сайжруулана” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилтын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Сургалтын чанарыг ахиулан, элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээс ахиц гаргана
- Багшийн хөгжил, мэдлэг боловсролыг дээшлүүлэх
- Ээлтэй сургалтын орчинг бий болгож, сургалтын чанарыг ахиулах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2020 оны А/28 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 255,5 сая төгрөгөөр буюу 15 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	142,437.0	236,142.5	93,705.5
Авлага	9,904.5	7,163.8	(2,740.7)
Урьдчилгаа			
Бараа материал	126,439.0	167,664.2	41,225.5
Үндсэн хөрөнгө	1,411,413.7	1,534,757.8	123,344.1
Нийт хөрөнгө	1,690,194.1	1,945,728.3	255,534.2
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,690,194.1	1,945,728.3	255,534.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,690,194.1	1,945,728.3	255,534.2

Мөнгөн хөрөнгө нь өмнөх оноос 93.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дансны авлага өмнөх оноос 2.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Бараа материалын данс 41.2 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын үлдэгдэлтэй нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 123.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн сургуулийн хичээлийн байрны их засвар болон нийлүүлсэн тоног төхөөрөмжтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгээр 388.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,156.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 309.7 сая төгрөг, нийт зарлагыг 2,466.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 380.4 сая төгрөгөөр бууруулж 2,085.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,418.6 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 285.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 128.6 сая төгрөг нийт 2,833.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,418.6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 152.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1.6 сая төгрөгийн орлого оруулж, оны эхний үлдэгдлээс 128.6 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,478.7 сая төгрөг буюу 87.5 хувьтай, дансанд 236.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80826	Байр ашиглалтын үйлчилгээ	3,256.1	2,954.3	301.8	90.7%
80223	Хүүхэд хамгаалал	3,437.4	3,086.0	351.4	89.8%
80312	Сургалт семинар	2,541.4	1,414.0	1,127.4	55.6%
81605	Эрүүл мэндийг дэмжих	4,750.9	3,096.4	1,654.5	65.2%
81801	Үдийн цай хөтөлбөр	58,901.3	54,207.5	4,693.8	92.0%
81806	Дотуур байрны үйлчилгээ	460,672.1	377,233.5	83,438.6	81.9%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	23,707.4	20,536.0	3,171.4	86.6%
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	10,218.4	2,889.5	7,328.9	28.3%
81827	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	17,860.7	17,578.2	282.5	98.4%
81834	Боловсролын стандарт, сургалтын	1,878,990.6	1,762,079.5	116,911.1	93.8%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	78,224.6	77,522.9	701.7	99.1%
81848	Сурах бичгийн түрээс	1,608.8		1,608.8	
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	4,748.8	3,959.1	789.7	83.4%
88011	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	285,044.0	152,178.0	132,866.0	53.4%
	Дүн	2,833,962.5	2,478,734.9	355,227.6	87.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

- Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу сан байгуулаагүй, ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй байна.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- БНАҮТХураамжийн данснаас гүйлгээ гараагүй, бараа үйлчилгээний бусад зардлаас 57.0 сая төгрөгний зардал гарсан үүнээс 20.5 сая төгрөг нь Монголын цахилгааны холбоо компаниас Ерөнхий гэрээгээр худалдан авсан интернет төхөөрөмжийн үнэ байна.
- Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Байхгүй

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг тухайн онд төлөвлөж ажилласан байна.

Батлагдсан төсвийн хүрээнд 291.3 сая төгрөгийн бараа материал, 35.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар тогтоосон суурь үзүүлэлтээр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 21,335.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж тайлант оны нийт зардлын дүн их хэмжээгээр өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 75 хувиар буюу 27,445.5 мянган төгрөгөөр тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 2,418.6 сая төгрөгийн 24 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 243.6 сая төгрөгийн 24 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 98.9 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 23.1 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөн ба бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	100.0	1	100.0	100%
Зөвлөмж	1	23,100.0	1	23,100.0	100%
Нийт	2	23,200.0	2	23,200.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалингийн зардал, хөрөнгийн тооллогыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **134,474.8** мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад **134,474.8** мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

Санхүүгийн байдлын тайланд тайлант оны авлагыг 132,866,0 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн төлөвлөгөөг 1,608.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн 4.1.3, 5 дугаар зүйл 5.1-ийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Сангийн сайдын 2023 оны А/229 тоот тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" болон УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **5,592.8** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, **3,984.0** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, **1,608.8** мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
БӨА-2025/155/НА-СТА-ТШЗ

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5.1 Төлбөрийн акт

Байхгүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар **3,984.0** мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв.

3. Сургуулийн захирлын 2024 оны “ Нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулах тухай” А/51, А/69 дугаар тушаалуудыг үндэслэн нягтлан бодогч, нярав нарт 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 3,984,0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5-ийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /дотуур байрны хоол хүнс 64.8 сая төгрөг, үдийн хоол 54.2 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд 1,608.8 мянган төгрөгийн түрээсийн сурах бичгийг сурагчдад тараасан боловч авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7-т “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 14

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтууд, иж бүрэн байх, ангилал, оршин байх гэсэн батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Түрээсийн сурах бичгийн тооцоогоор үүссэн авлагыг санхүүгийн тайланд авлагаар бүртгэж тайлагнаж байх.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд тайлант оны авлагыг 132,866,0 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав	1	132,866.0			1	132,866.0	1	132,866.0				
ТГТ-д БГНАУТХ-жийн төлөвлөгөөг дутуу тайлагнасан	1	1,608.8			1	1,608.8	1	1,608.8				
Дүн	2	134,474.8			2	134,474.8	2	134,474.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хууль тогтоомж зөрчин балансын шагнал олгосон	1	3,984,0			1	3,984,0					
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй	1	0					1	0			
Түрээсийн сурах бичгийг сурагчдад тараасан боловч авлагаар бүртгээгүй	1	1,608.8					1	1,608.8			
Дүн	3	5,592.8			1	3,984,0	2	1,608.8			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн								